

Монгол хэлний нэрийн хоршоо үгийн үүсэл ба  
түүхэн хөгжил

Сэржээгийн МӨНХСАЙХАН<sup>1</sup>

Монгол Улс, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академи,  
Хэл зохиолын хүрээлэн, Хэл шинжлэлийн салбар

**Submitted:** September 25, 2025 | **Accepted:** November 15, 2025

*Хураангуй:* Монгол хэлний хоршоо үг нь эртний монголчуудын хийсвэрлэх сэтгэлгээний онцлогийг шингээсэн үгийн сан, утга зүй, өгүүлбэр зүй, найруулга зүйн учир холбогдолтой хэлний тун сонирхолтой судлагдахуун юм. Бид Монголын нууц товчооны жишээ баримтад тулгуурлан монгол хэлэнд нэрийн хоршоо үг үүссэн олон нөхцөл шалтгаан хийгээд түүхэн хөгжлийг тайлбарлав. Онцлон дурдвал, эртний монголчуудын үг холбох эрдэмд суурилсан уран сайхны сэтгэлгээгээр аман зохиолын эртний төрөл зүйл үүсэж, үгийн урлагийн гайхамшигийг илтгэсэн аман соёлын өв бүрэлдэх нөхцөл бүрдсэн байна. Улмаар хүмүүсийн сэтгэн бодох чадвар сайжрахыг дагалдан уран сайхнаар шүлэглэн холбохын зэрэгцээ, дунд нь ойролцоо болон эсрэг утгатай, эртний монголчуудын үнэлэмж бүхий шингэсэн зэрэгцүүлэл шүлгийг шигтгэх болжээ. Улмаар тэрхүү өгүүлбэр зүйн хоршоо зэрэгцүүлээ хураан товчилбол хоршоо үг, хийсвэрлэн дүгнэвэл хэлц үг үүссэн байна.

*Түлхүүр үг:* хоршоо үг, Монголын нууц товчоо, хэлний түүхэн хөгжил, танин мэдэхүйн сэтгэлгээ, уран сайхны сэтгэлгээ

**Origins and Historical Development of Mongolian Compound Words**

MUNKHSAIKHAN Serjee

Department of Linguistics, Institute of Language and Literature,  
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

<sup>1</sup> © С.Мөнхсайхан, 2025

Email: [munkhsaikhans@mas.ac.mn](mailto:munkhsaikhans@mas.ac.mn)

***Abstract:** According to linguistic evidence from *The Secret History of the Mongols*, early Mongols developed ways to express newly discovered natural and social phenomena by combining words — a process rooted in their oral cultural tradition. As their cognitive and linguistic capacities evolved, they began to use rhyme and creativity to connect words more artistically. Over time, stories and expressions passed down orally transformed into a rich literary heritage that reflected the artistry of language. This oral literature was often sophisticated and vivid; some genres, such as epics, extended to thousands of lines, illustrating what can be described as a cognitively “differentiative” mode of thinking. However, as cognitive styles shifted and abstraction skills improved, Mongols began to condense and summarize these detailed expressions. Consequently, syntactic compounds with similar or contrasting meanings emerged. This development laid the groundwork for new forms of Mongolian oral literature — including proverbs and *Yertöntsiin gurav* (“*The Three of the World*”) — as well as the creation of new morphological compound units. At more advanced stages of cognition, compounds arose through condensation of compound phrases, while idioms emerged when these expressions were further abstracted through evaluative judgment.*

***Keywords:** compound words, *The Secret History of the Mongols*, historical development of language, cognitive thinking, creative thinking*

## 1. Удиртгал

Монгол хэлний хоршоо үг нь монголчуудын олон зуун жилийн хийсвэрлэх сэтгэлгээний үр дүн бөгөөд монгол хэлний үгийн сан, утга зүй, өгүүлбэр зүй, найруулга зүйн учир холбогдолтой хэлний түүхэн үзэгдэл билээ. Товчоор хэлбэл, хоршоо үг бол монголчуудын байгаль, нийгмийн юмс үзэгдлийн шалтгаант холбоог танин мэдсэн туршлага, сэтгэлгээний хөгжил, түүний цар хүрээ, үндэстний ахуй амьдралын хэв маяг, соёл, ёс заншил зэрэг олон зүйлийг өөртөө шингээсэн хэлний товч илэрхийлэл юм.

Монгол хэлний хоршоо үгийн үүсэл гарлын тухай ярина гэдэг нь цаг хугацааны хувьд нэлээн эрт цагт холбогдох нь мэдээж. Байгаль нийгмийн тухай маш өргөн утга агуулга бүхий зүйлийг хоёрхон үгээр товчлон илэрхийлнэ гэдэг нь сэтгэлгээний хувьд тун нарийн хийсвэрлэл бөгөөд үүсэл гарлыг нь зөвхөн эрт цагийн хэлний баримт (эртний бичгийн дурсгал)-д тулгуурлан тодорхойлох боломжтой. Үүнээс бид чухам хэзээнээс хийсвэрлэн сэтгэдэг болсон бэ? гэдэг асуулт зүй ёсоор гарна. Байгаль ертөнцийн юмс үзэгдлийн хувьсан хөгжих зүй тогтол нь цөмөөс зах руу, энгийнээс нарийн руу, бодитоос хийсвэр лүү, ганцаас олон руу чиглэдэг онцлогтой. Энэхүү тодорхойлолт нь хэлний хийсвэрлэл бол урт удаан түүхэн хөгжлийн явцад үүссэн болохыг илтгэнэ.

Монголчуудын сэтгэлгээний хөгжлийн хамгийн эрт цагийн баримт болох домог үлгэрүүдийг судлан үзвэл, эртний хүмүүс анхандаа орчин үеийн хүмүүс

шиг гүнзгий хийсвэрлэн сэтгэдэг байсангүй, тэд өөрсдийн мэдлэг чадварын хэмжээнд байгаль ертөнцийн олон үзэгдлийг тайлбарлахыг оролдож байв. Өөрөөр хэлбэл, уран сайхны хийсвэр сэтгэлгээгээр юмс үзэгдлийн учир шалтгааныг тайлбарлаж байв. Харин юмс үзэгдлийн нүднээ үл үзэгдэх далд холбоог танин мэдсэн тэр цагаас эхлэн хийсвэрлэх чадвар нэмэгдсэн хэмээн багцаалж болно. Тухайлбал, эртний монголчууд байгаль цаг уурын олон үзэгдлийн учир шалтгаан, холбоо хамаарлыг мэдэхгүй тул түүнийг “ямар нэг далдын агуу хүч”-тэй холбон, байгалийн үзэгдэл бүр өөр өөрийн тус тусдаа учир шалтгаантай хэмээн боддог байсан нь “Цахилгаан цахидаг болсны учир”, “Өвөл зун яагаад ээлжилдэг вэ” (Цэрэнсодном, 2011: 381-382) гэх мэт домог үлгэрээс харж болно. Тиймээс энэ үед юмс үзэгдлийг танин мэдэхдээ тэдгээрийн бие биеэсээ ялгарч буй шинжийг (нүднээ ил үзэгдэх шалтгаант холбоог) чухалчлан үздэг байсан ба өөрөөр хэлбэл, “ялгах”, “салгах” үйлдлээр бүхий л зүйлийг айчлан, мэдлэгээ нэмэгдүүлж танин мэдэхүйн цар хүрээгээ тэлдэг байв. Хожим юмс үзэгдлийн далд учир шалтгааныг тайлснаар бидний нүдэнд үзэгдэхгүй, гарт баригдахгүй олон үйл явц байгаль ертөнцөд өрнөж байдгийг “нээж”, тэр хэрээр танин мэдэхүйн туршлага нэмэгдсэн байна. Иймээс шаардлагагүй, мэдээжийн зүйлийг товчилдог, орхидог болсон ба өөрөөр хэлбэл, хийсвэрлэн сэтгэдэг болсон байна. Энэ мэт хүний танин мэдэхүйн үйл ажиллагаа хэлэндээ хэрхэн тусаж буйг судалдаг хэл шинжлэлийн салбарыг танин мэдэхүйн хэл шинжлэл гэж нэрлэдэг. Танин мэдэхүйн хэл шинжлэлд хэл бол хүн бодит ертөнцийг танин мэдэж, өөрийн өвөрмөц сэтгэлгээгээр илэрхийлэх үйл явц гэж үзэх ба танихуйн үйл ажиллагаа нь хэлийг загварчилдаг, хэлний нэгж болон хэл зүй нь танин мэдэхүйн үйл ажиллагааны хэлзүйжсэн загвар, үйл явц хэмээн үздэг. Иймээс танин мэдэхүйн хэл зүйд үгийн сан болон хэл зүйг тодорхой ялган заагладаггүй, давхраат гинжин холбоот зүйл хэмээн үздэг (Нансалмаа, Долгор, 2014: 209-210, 221). Учир нь, хэл зүйн нөхцөлийн үндсэн үүрэг бол үгийг холбох бөгөөд өөрөөр хэлбэл, үгэнд харьцаа заах хийсвэр утга нэмж, улмаар үгийн утга болоод хэл зүйн утга нэгдэн бодит ертөнцийн тухай мэдээллийг дамжуулдаг. Иймээс эрт цагийн бичгийн дурсгалуудад хэл шинжлэлийн гүнзгийрүүлсэн судалгаа хийх нь тухайн үеийн хүмүүсийн хэл, сэтгэлгээний онцлогийг тодруулах боломжийг олгодог. Бидэнд уламжлан ирсэн Монголын нууц товчоо зэрэг эртний бичгийн дурсгалуудыг шинжлэн үзвэл ард түмний дунд түгсэн аман соёл нь тухайн цагийн утга зохиолын хэлний хөгжилд онцгой нөлөө үзүүлсэн бөгөөд улмаар хэл, соёл, сэтгэлгээний хөгжлийн уулзварт үгийн сангийн шинэ нэгж буюу “хоршоо үг” үүсэх нөхцөл бүрдсэн байна.

## 2. Судалгааны арга зүй

Монголын нууц товчооны жишээ баримтад тулгуурлан монгол хэлний нэрийн хоршоо үгийн үүсэл гарлын тухай өөрсдийн таамаглалыг дэвшүүлэх, мөн хоршоо үг бол монголчуудын сэтгэлгээний хөгжлийн үр дүн болохыг нотлохыг зорив. Судалгааны зорилгодоо хүрэхийн тулд Монголын нууц товчооны өгүүлбэрийн бүтэц, найруулгад ажиглалт хийн дундад зууны монголчуудын сэтгэлгээний онцлог (танин мэдэхүйн болон уран сайхны)-ийг

тодруулах, улмаар танин мэдэхүйн үүднээс Монголын нууц товчооны хэл зүйн онцлогийг тайлбарлах, түүнчлэн хоршоо үгийн хэл зүйн болон дундад зууны монголчуудын танин мэдэхүйн ялгах сэтгэлгээний онцлогт тулгуурлан монгол хэлний хоршоо үгийн үүсэл гарлыг тодруулах судалгаа хийхээр зорив.

Үүний тул ажиглалтын аргад тулгуурлан хэлний баримтыг задлан шинжилж, өөрсдийн таамаглалыг дэвшүүлэн Монголын нууц товчооны жишээ баримтаар баталж улмаар нэгтгэн дүгнэв.

Судалгаанд Японы Монголын нууц товчоо судлаач Х.Күрибаяши, Өвөр Монголын эрдэмтэн Чойжинжав нарын 2001 онд хэвлүүлсэн латин галиг эхийг гол хэрэглэгдэхүүн болгон ашиглав. (Kuribayashi. H., Choijinjab. (2001) Word-and Suffix-Index to “The Secret History of the Mongols” (元朝秘史, 語全単語-語尾索引) based on the Romanized Transcription of L.Ligeti, Center for Northeast Asian Studies №4, Sendai 2001).

### 3. Монгол хэлний нэрийн хоршоо үг

Монгол хэлний хоршоо үгийн үүсэл гарлыг тодорхойлохын тулд эрт цагийн бичгийн хэлний дурсгалуудыг нягтлан судлах хэрэгтэй болдог тул ийм төрлийн судалгаа харьцангуй цөөн хийгджээ. Монгол хэлний хоршоо үгийн үүслийг доктор (Sc.D), профессор М.Базаррагчаа, Д.Бадамдорж (2023) нар үгийн утгын хөгжилтэй холбон тайлбарласан бол МУИС-ийн багш Ч.Баттулга “Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр хураагдаж зэрэгцсэн нийлмэл гишүүнтэй энгийн өгүүлбэр үүсгэж, улмаар зэрэгцсэн гишүүд нь ойролцоо юмуу эсрэг утгаараа авцалдан хосолж хоршоо үгийг үүсгэжээ. Тодруулбал, хоршоо үг нь хоёр үг нийлэх аргаар бус олон зэрэгцсэн нийлмэл үгээс ойролцоо эсрэг болон бусад утгын хамааралтай үгс хоцорч үлдэх буюу хураагдах аргаар үүссэн гэсэн санал дэвшүүлж байна” (Баттулга, 2012: 74) хэмээн тун сонирхолтой ажиглалт хийжээ. Өөрөөр хэлбэл, тэрбээр хоршоо үгийг өгүүлбэр зүйн судлагдахуун болохын хувьд авч үзэн, судлаачдын ажиглалт дүгнэлтийг нэгтгэн дээрх дүгнэлтийг хийсэн байна. Тэгвэл бид түүний дүгнэлтийг Монголын нууц товчоонд тэмдэглэгдсэн хэлний жишээ баримтаар илүү гүнзгийрүүлэн тайлбарлая. Монголын нууц товчоо бол монголчуудын олон зуун жилийн турш бүтээн хөгжүүлсэн аман соёлын өвд суурилсан, монгол хүний уран сайхны сэтгэлгээ буюу шүлэглэх эрдмээр амилсан, монгол утга зохиолын хэлний хөгжилтөд онцгой нөлөө үзүүлсэн, дундад үеийн монгол хэлний хосгүй үнэт дурсгалт бичиг билээ.

Монголын нууц товчооны үгийн сангийн утгын бүрдүүлбэрийн онцлогийг ажиглавал, хүний танин мэдэхүйн үйл ажиллагаанд суурилан үгийн утга салаалан хөгжих ба ингэж шинэ мэдлэг бүтээх бүрд түүнийг үгийн сангийн дан нэгжээр илэрхийлэх хэлний боломж нь хязгаарлагдмал тул хам бүтцээр буюу холбоо үгээр тэмдэглэх аргатай болсон байна. Жишээ нь, Монголын нууц товчоонд гарах “Гол даарьт годил сүүлт орог шунхлыг унаж” гэдэг хэллэг нь “нуруундаа сорвитой, охор бөгөөд үсгүй сүүлтэй орог шунхал” зүсмийн адууг заана. Эртний монголчууд танин мэдэхүйд юмсын ялгаа, онцлог шинжийг чухалчилдаг байсан тул малаа онцгой содон шинж, зүсээр нь нэрлэдэг заншилтай. Тэгвэл тэрхүү адууныхаа онцлогоор буюу “годил сүүл”-ээр

адилтган өөрсдийн хийсэн сумаа “годил сум” (харвах сумны үзүүрт эвэр яс зэргээр булцуу хийсэн дуут сум) хэмээн нэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, хоёр зүйлийн гадна хэлбэр адил учир ийнхүү нэрлэжээ. Улмаар тэрхүү годил сумаар харвахыг “годилдох” гэдэг. Үүнээс үзвэл дундад үеийн монгол хэлэнд шинэ нэрлэлт үүсгэж буй зүйрлэл нь юмсын гадна хэлбэр дүрс, холбоо харилцаанд үндэслэсэн байна. Ингэж хэлний шинэ нэрлэлт үүсгэх нь нийгэм түүхийн нөхцөл байдалтай шууд холбоотой, өөрөөр хэлбэл, нийгмийн хувирал хөгжил, хүмүүсийн танин мэдэхүйн цар хүрээ өргөжихийн хэрээр шинэ үг, шинэ ухагдахуунаар баяжихын хамт нийгмийн хөгжлийн дараагийн шатанд зарим юм үзэгдэл, ойлголт хуучирч мартагдахыг дагалдан нэг хэсэг нь идэвхтэй хэрэглээнээс гардаг. Иймээс зарим үед тухайн үгийн салаа утга мартагдана, зарим үед шинээр нэмэгдсээр утгын багтаамж харилцан адилгүй олон мянган үгийн сан бүрэлдэн тогтсон байна. Иймээс монгол хэлний олон салаа утгатай үгийн хувьд тухайн үгийн аль нэг утга идэвхжээгүй тохиолдолд хамгийн ерөнхий, хийсвэр утга илтгэдэг бол холбоо үгийн тусламжтайгаар аль нэг утга нь идэвхжихэд тодорхой, ялгасан утга илэрхийлдэг онцлогтой ажээ. Үүнээс үзвэл үг холбох арга нь мэдлэгийн үр дүн төдийгүй танин мэдэхүйн үйл ажиллагаатай шууд холбоотой болох нь харагдаж байна.

Нүүдэлчдийн өдөр тутмын амьдрал нь өөрсдийнх нь амьдран буй газар нутгийн онцлог, байгаль цаг уурын хувирал өөрчлөлттэй дасан зохицсон хэв маягийг бүрдүүлсэн байдаг. Энэ нь тэдний сэтгэлгээнд шууд нөлөөлнө. Тухайлбал, монголчуудын зүйрлэх сэтгэлгээ (жишин харьцуулалт) нь тэдний өөрсдийнх нь амьдралаас олж авсан туршлагын мэдлэг буюу орчин тойронтойгоо харилцах харилцаанд аяндаа бий болсон бодит төсөөллөөс бүтдэг онцлогтой. Иймээс уран сайхны сэтгэлгээнд юмсын адил төстэй шинжийг ашиглан зүйрлэл бүтээдэг. Жишээ нь, “*Олон хоньд чоно үлдэж хотонд хүртэл үлдэж ирэх мэт*” [olon qonit činō hüldejü qoton-tur gürtele hüldejü iregü metü 195§] гэсэн хэллэгийг шинжлэн үзвэл, мал аж ахуй голлон эрхлэх монголчуудын хувьд энэ нь балчир хүүхэд ч мэдэх энгийн мэдлэг юм. Тиймээс чононд хөөгдсөн олон хонь хэрхэн үймж сандран, хошууралдан хуйлрахыг мэддэг мал маллах туршлагадаа үндэслэн Найманы харуулыг Наху хуны өвөрт байх их голд нь нийлтэл үлдэн хөөснийг ийнхүү зүйрлэн дүрсэлсэн байна.

Тэгвэл танин мэдэхүйн сэтгэлгээнд юмсын бие биеэсээ ялгарч буй шинжийг онцолдог байсны баримт нь Монголын нууц товчооны хэл зүйд илрэх тоо, хүйсээр ялгадаг онцлог юм. Тухайлбал, *цагаанууд шонход* [čaqa’anu’ut šingqot 239§], *гурван шөнөд гурван өдөд* [qurban sönit qurban üdüt 185§], *Нүдэндээ галт нүүртээ гэрэ[л]т хөвүүн буй* [ene kö’ün čin-u nidün-tür-iyen qaltu ni’ur-tur-iyen geretü kö’ün büi. 62§], *Охин ину үзвээс нүүртээ гэрэ[л]тэй, нүдэндээ галтай охиныг үзэж ойндоо оруулав* [öki in-u üjebesü ni’ur-tur-iyen geretei nidün-tür-iyen qaltai ökin-i üjējü oyin-tur-iyen oro’ulba. 62§], *Тэнгэр дээр наран сар хоёр гэрэ[л]тэн гэгээн болтугай хэмээн наран сар хоёр буй зэ* [tenggeri de’ere naran sara qoyar gereten gege’en boltuqai ke’en naran sara qoyar büi je. 189§] гэх зэргээр хэлдэг байв.

Дундад зууны монголчуудын танин мэдэхүйн ийм ялгах сэтгэлгээний онцлог хэл, соёл (бөө мөргөл, зан үйл, аман соёл)-ын олон баримт дээр маш тод ажиглагддаг. Тухайлбал, доктор (Sc.D), профессор С.Дулам монголчуудын гал

бэлгэдэх ёсны тухай өгүүлэхдээ энэ ёс нь анхандаа ямар нэг бэлгэдлийн утга агуулгатай байгаагүй, зөвхөн байгалийн нэгэн үзэгдлийг таньж мэдэх гэсэн эртний хүмүүсийн эрмэлзэл байжээ гээд “Тухайлбал, “гал өөдөө, ус уруугаа” гэсэн харшуулал бүхий томьёололд юм үзэгдлийн шинж төрхийг таньж мэдэх гэсэн эртний хүний эрэл байна гэж хэлж болно. Юу гэвэл, хүн анх галтай болоод илч гэрэлд нь хөлчин баясаж, байгалийн хүйтний нэгэн гамигсаас биеэ хамгаалдаг болохын хамт хэзээ ямагт өөдөө өөдлөн бадардаг галын эрхэм нэгэн чанарыг таньж, сэтгэл урам нь хөгжихдөө “гал өөдөө” гэдэг томьёолол гаргажээ. Энэ бол хүн байгалийн үзэгдлийн шинж байдлыг нэг нэгээр таньж эхэлсний гэрч мөн. Гэтэл дараа нь үргэлж өөдөө бадардаг халуун чанартай зүйлийн эсрэг үргэлж уруугаа урсдаг хүйтэн чанартай нэгэн үзэгдлийг харшуулан жишээд “гал өөдөө, ус уруугаа” гэж хэлэх болжээ. Энэ тохиолдолд хүн зөвхөн юм үзэгдэл болон түүний шинж чанарыг тус бүрчлэн таньсан төдийгүй бусад үзэгдэл, тэдгээрийн шинж байдалтай харьцуулж улам тод болгосон нь харагдаж байна. Ингэхдээ энд бол өмнө дурдсан ёсоор ямар нэгэн хийсвэрлэл, бэлгэдлийн утга огтхон ч үгүй, зөвхөн тухайн шинжийг тухайн юм үзэгдэлд оногдуулж хэлсэн зүйл байна” (Дулам, 2018: 35) хэмээн тайлбарласан нь мөн чанартаа эртний монголчуудын юмс үзэгдлийг тус бүрд нь ялган таньж тодорхойлдог сэтгэлгээний онцлогийг өгүүлсэн хэрэг билээ. Сэтгэлгээний ийм онцлогтой байсан тул Монголын нууц товчоонд үйл явдлыг маш тодорхой, дэлгэрэнгүй, ойлгомжтой (нэг бүрчлэн өгүүлдэг ч гэж хэлж болно) өгүүлдэг. Орчин цагийн хүмүүсийн ойлголтоор бүр шаардлагагүй зүйлийг хүртэл тодорхой хэлж буй мэт санагдах нь дурдсан “ялгах сэтгэлгээ”-ний онцлог ажээ. Тухайлбал, 87-р зүйлд,

*Эдүгээ эхээ дүү нэрээ эрэн од хэмээж аман цагаан эрмэг хулагчныг унуулж, тэл хурган болгож хөхүүр намбуга засаж эмээл үл өгөн, хэт үл өгөн, нум өгч хоёр сум өгөв. [edö'e eke-ben de'ü-ner-iyen erin ot ke'ejü aman čaqa'an eremük qulaqčïn-i unu'ulju tel quriqan bolqaju gö'ür nambuqa jasaju eme'el ülü ögün, kete ülü ögün numu ökčü, qoyar sumu ökbe.]*

хэмээн өгүүлдэг. Үүнд, Тэмүжинд унуулж буй морь нь “ам цагаан”, “эрмэг”, “хул зүс”-тэй бөгөөд мөн эмээлгүй, болгож чанаж өгч буй мах нь тэлээ хурганых, түүнийгээ хөхүүр намбуга (арьсаар хийсэн сав)-нд уудалсан, нэмээд нум өгсөн, бас хоёр сумтай, харин хэт өгөөгүй гэжээ. Орчин цагийн хүмүүсийн сэтгэлгээгээр ингэж Тэмүжинд өгсөн зүйлийг маш нарийн тодорхой дүрсэлж буй нь үүний дараа ямар нэг хэрэг учрыг өгүүлэхийн тулд ийнхүү хэлсэн мэт санагдана. Гэвч дараагийн зүйлд зөвхөн гэртээ харьсан тухай л өгүүлнэ. Иймээс орчин цагийн хүмүүст 87-88-р зүйлийн хоорондох үйл явдлыг орхисон, эсвэл эх бичиг нь дундаа тасарсан юм шиг сэтгэгдэл төрөх ажээ. Гэтэл бичлэгийн ийм хэв маяг нь дундад зууны монголчуудын ялгах сэтгэлгээний нөлөө юм. Энэ мэтчилэн 114-р зүйлд

*Удуйд мэргид дүрвэрүүн, булган малгайт, марлын годон гудуст илгэн жархаг, усны булга залгасан дээлт таван наст Хүчү нэрт*

*нүдэндээ галт хөвүүхнийг бидний цэргүүд нунтугт хоцорсныг олж авчирч Өгэлүн эхэд сауха авч одож өгвэй.* [Uduyit\_merkit dürberün buluqan maqalaitu maral-un qodun qudusutu i<ci>[I]kin jarqaq usun-u buluqan jalqaqsan de'eltü tabun nasutu Kücü neretü nidün-dür-iyen qaltu kö'üken-i bidan-u çeri'üt nuntuq-tur qoçoruqsan-i olju abçiraju Hö'elün eke-de sauqa abçu otçu ökbei.] гэжээ.

Жишээнд Өгэлүн эхэд авчирч өгсөн хүүгийн тухай өгүүлсэн бөгөөд тэрбээр Удуйд мэргэдийнх, булган малгайтай, марлын годон гуталтай, сайтар боловсруулсан илэг, усны булга залгасан дээлтэй, Хүчү нэртэй, нүдэндээ галтай, Мэргидийн нутагт хоцорсон, хүү байсан хэмээн маш дэлгэрэнгүй, тодорхой дүрсэлжээ. Өөрөөр хэлбэл, гарал угсаа сайтай хүү болохыг ийнхүү дэлгэрэнгүй тодорхойлон бичжээ. Энэ мэтчилэн зохиолын үйл явдлын тухай болон гол баатрын хаа хаагуур явж ирсэн тухай нэг бүрчлэн өгүүлдэг нь мөн л дундад зууны монголчуудын танин мэдэхүйн сэтгэлгээний онцлог юм. Тухайлбал, 115-р зүйлд Тоорил хан буцсан тухай

*Тоорил хан ичруун, Бурхан халдуны хэрүүгээр Өхөртү жубур дайран Хачагурату субчид, Улиату субчид дайран гөрөө инү авлаад Туулын Хар түнг зорин ичвай.* [To'oril qan icurun Burqan\_qaldun-nu gerü-ber Hökörtü\_jubur da'arin Qaça'uratu\_subçit Huliyatu\_subçit da'arin görü'en in-u abala'at Tu'ula-yin Qara\_tün-ni jorin icubai.]

гэх зэргээр өгүүлдэг. Гэвч яваандаа хэлний хэмнэх зарчмын нөлөөгөөр ийнхүү дэлгэрэнгүй, тодорхой дурддаг байсан зүйлээ хураан товчлох болсон байна. Шалтгаан нь, хүмүүсийн мэдлэг нэмэгдэхийг дагалдан хийсвэрлэх чадвар сайжран шаардлагагүй зүйлийг хураан товчилдог, эсвэл дурдалгүй орхидог болсон байна. Өөрөөр хэлбэл, юмс үзэгдлийг танин мэдэхдээ бие биеэсээ ялгарах шинжийг нь онцолж дэлгэрэнгүй өгүүлдэг байснаа зөвхөн шаардлагатай тохиолдолд ялгадаг болсон байна. Тухайлбал, Монголын нууц товчооны 99-р зүйлд

*Тэмүжинтан хөвүүд үтэрлэн-хүү босоод морьдоо барьж Тэмүжин нэгэн морь унав. Өгэлүн эх нэгэн морь унав. Хасар нэгэн морь унав. Хачигун нэгэн морь унав. Тэмүгэ отчигин нэгэн морь унав. Бэлгүдэй нэгэн морь унав. Боорчу нэгэн морь унав. Зэлмэ нэгэн морь унав. Тэмүлүнийг Өгэлүн эх өвөртөө дүүрэв.* [Temüjin-tan kö'üt öterlen gü bosu'at morid-iyen bariju Temüjin niken mori unuba. Hö'elün eke niken mori unuba. Qasar niken mori unuba. Qaçi'un niken mori unuba. Temüge\_otçigin niken mori unuba. Belgütei niken mori unuba. Bo'orçu niken mori unuba. Jelme niken mori unuba. Temülün-ni Hö'elün eke ebür-tür-iyen de'ürbe.]

хэмээсэн нь нэр дурдсан хүмүүсийг тус тусдаа морь унасныг ялган өгүүлсэн хэрэг юм. Яваандаа ингэж дэлгэрэнгүй, тодорхой өгүүлэхээ больж, орчин цагт

*Тэмүжин, Өгэлүн эх, Хасар, Хачигун, Тэмүгэ отчигин, Бэлгүдэй, Боорчу, Зэлмэ нар тус бүр нэжгээд морь унав* хэмээн хураах болжээ. Ингэснээр физиологийн талаас өгүүлэхийн эрхтэн энерги арвилах ба хэлний талаас хэмнэлт хийсэн байна. Хэлний энэхүү хэмнэх зарчим үгийн сангийн түвшинд ч мөн үйлчилнэ. Жишээ нь, Монголын нууц товчоонд Өгэлүн үжин болон түүний хөвүүд Тэмүжин, Хасар, Хачигун, Тэмүгэ, мөн Сочигэл болон түүний хөвгүүд Бэгтэр, Билгүүдэй нарын нэрийг олон давтан хэлэх өгүүлэхүйн үйл ажиллагааг хэмнэн “эхэс хөвүүд” хэмээн хоршоо үгээр ерөнхийлөн хэлжээ. Бүр тодруулбал, нэр дурдсан бүлэг хүмүүсийг бие биеэс нь ялган салгавал нэг хэсэг нь эхчүүд, нөгөө хэсэг нь хөвүүд байх тул “эх”, “хөвүүн” гэсэн үгээр тэдгээр хүмүүсээ төлөөлүүлэн, тус тусад нь ялгасан учир “эхэс хөвүүд” хэмээн олон тооны нөхцөлөөр тус тусад нь хэлбэржүүлсэн байна. Түүнчлэн энэхүү ерөнхийлөн төлөөлүүлсэн болон бүлэглэсэн хоршоо үг нь танин мэдэхүйн ялгах сэтгэлгээний нөлөөгөөр хэл зүйн нөхцөлөөр харилцан адилгүй хувилдаг байв. Тухайлбал, “ах дүү” гэдэг хоршоо үг

-Төлөөлүүлсэн хүмүүсээ тус тусдаа гэж ойлговол (ялгавал) “ах нар дүү нэр” хэмээн тусад нь хэл зүйн нөхцөлөөр хувилгана. Жишээ нь, *Эх юүгээ Алангоо-ыг үгүй болсны хойно ах нар дүү нэр тавуул адуусан идээгээ хуваалдруун Бэлгүндэй, Бүгүндэй, Буху хатаги, Бухату салжи дөрвүүл авалцав.* [eke-yü'en Alan\_qo'a-yi ügei boluqsan-nu qoyina aqa-nar de'ü-ner tabu'ula adūsun ide'e-ben qubiyaldurun Be[l]günütei Bүgүнütei Buqu\_qadagi Buqatu\_sa[l]ji dörbe'üle abulcaba. 23§]

-Төлөөлүүлсэн хүмүүсээ хамтдаа гэж ойлговол (үл ялгавал) “ах дүүгийнхээ”, “ах дүүгээ” гэх мэтээр сүүлийн үгэнд хэл зүйн нөхцөл залгана. Жишээ нь, *Тайчууд ах дүүгийнхээ гашуу хэр аврахун бид хэмээж бүхүйд эрт Алан эхийн таван хөвүүд мэт яахан эе үгүйн буй та нар.* [Тауүи'üt aqa de'ü-yeуen qaši'u ker aburaqun bida ke'eјü бүkүi-tүr erte Alan eke-yin tabun kö'üt metü yekin eye üge'ün бүi ta. 76§], *Зэ тийн Баягуд ах дүүгээ чуулгаж чи мэд мянган хэмээн зарлиг болов.* [je teyin Baya'ut aqa de'ü-yen či'ulqaju či mede minqan ke'en jarliq bolba. 213§] гэх мэтээр хэлдэг байжээ. Иймээс Монголын нууц товчоонд утгын харьцаанд эсрэгцсэн, эсрэг утгатай үг харьцангуй цөөн харин ерөнхийлөн төлөөлүүлсэн, ерөнхийлөн бүлэглэсэн ойролцоо утгатай үг олон байдаг. Жишээ нь, харь ширидээс [qari širi-deče 123§], өвгөс эцэгсийг [ebüges ečiges-i 133§], эхэс хөвүүдийг [ekes kö'üd-i 72§], иргэн оргоноо [irge orqa-ban 177§], үнээд хоньдоо [üni'et qoni<n>d-іyan 189§], орд гэрт [ordo ger-tür 232§], улс иргэнээ [ulus irgen-e 279§], хэрэг заргаа [kerek jarag-іyan 281§], ах дүүдээс (дүүгээс) [aqa de'ü-deče 281§], улс иргэний [ulus irgen-ü 281§], эрс ардаас [eres harad-ača 123§] гэх мэт.

Ийнхүү хэлний хөгжлийн дараагийн шатанд хүмүүсийн хийсвэрлэх чадвар улам сайжрахыг дагалдан өдөр тутмын ахуй амьдрал, дадал зуршлаас урган гарсан соёл, ёс заншилтай холбоотой олон тооны хоршоо үг үүсжээ. Жишээ нь, наран сарын хил (үүр шөнийн зааг) [nagan sara-yin 21§], тэнгэр газрын (дэлхий дахин, хувь заяа, оршин тогтнол, хүч нөлөө) [tenggeri qajar-un 177§], өмнө үмрээ (дураар) [emüne ümere-en jarutuqai 185§], тэнгис далайд (их ус) [tenggis dalai-tur 199§], өрнө үмрээс (баруун хойноос) [hörene ümere-eče 31§], тэнгэр газраа [tenggeri qajar-a 260§], газар усаа (нутаг дэвсгэр, нутаг орон) [qajar usun-іyan

272§], ус өвснөө (нутаг бэлчээр) [usun ebesün-e 281§] гэх мэт. Ингэж хоршуулан хэлэх болсны шалтгаан нь, тухайлбал, “наран сар” хэмээсэн нь хүмүүн төрөлхтөн тэнгэр газар, наран сарны эрхшээлд амьдардаг, наран саргүй бол энэ дэлхийд амьдрал үгүй гэдгийг илэрхийлнэ. Тэдний ойлголтоор бидний амьдарч буй эх дэлхийг өдөр нь нар, шөнө нь сар гэрэлтүүлэн гийгүүлж байдаг, аль нэг нь үгүй бол энэ ертөнцийн амьдрал бас үгүй гэсэн санаатай. Учир нь, тэд нарны нөлөөгөөр сар шөнө гэрэлтдэг гэдгийг мэдэхгүй учир “наран сар” хоёрыг адилтган үздэг байсан тул дэлхий ертөнцийн амьдралыг “наран сар”-аар төлөөлүүлэн бэлгэдэж байжээ. Тэрчлэн “тэнгэр газар” хэмээн хоршуулсан нь тэнгэр нь хүрч үл чадах өндөрт орших учир дээдийн дээд, агуу хүчний орших орон бол газар нь хүн, амьтан, ургамлын шим тэжээлийн уг сурвалж, оршин тогтнолын үндэс учир төрүүлсэн эх адил дотночлон хандана. Хоёр үгийг хоршуулснаар энэ ертөнцийн хүн, амьтан, ургамал бүхий л амьтай болгон энэ хоёрын дунд буюу тэнгэр газрын шүтэлцээнд дулдуйдан амьдарна гэсэн утгатай ажээ. Иймээс ийм хоршоо үг утгын гүн бүтцэд бүрэн нэгдэж, гурав дахь утга илэрхийлж, хэл зүйн нөхцөлөөр сүүлийн үг хувилна. Өөрөөр хэлбэл, ийм үгс нь анхнаасаа утгын холбоонд гүн нэгдэж, үгийн сангийн нэг нэгж байсныг илтгэнэ. Хэлний түүхэн хөгжлийн явцад танин мэдэхүйн “ялгах” сэтгэлгээ өөрчлөгдөхөд хоршоо үг утгын гүн бүтцэд бүрэн нэгдэх болсноор орчин цагт хоршоо үгэнд үгийн сангийн утгаас илүү соёл хэрэглээний хийсвэр утга давамгайлах болжээ. Өөрөөр хэлбэл, орчин цагийн монгол хэлний хоршоо үг ихэвчлэн хийсвэр утгатай, бүрэлдэхүүнд буй хоёр үг нийлж гурав дахь утга илэрхийлдэг болсон байна. Гэхдээ дундад үеийн монгол хэлэнд байсан энэхүү “ялгах сэтгэлгээ”-ний ул мөр орчин цагийн монгол хэлэнд хадгалагдан үлдсэн бөгөөд энэ тухай академич Б.Ринчен “Монгол бичгийн хэл зүй”-дээ “*хоршоо үгийн гишүүн бүрд нь онцлон зааж чангаруулах санаа байваас, үг тус бүрд нь дагавар дагуулан чангаруулах ёсон бас бий: Хичээх мэрийхгүйгээс л болж байгаа хэрэг! Хичээхгүй мэрийхгүй байж болох уу? Харах үзэхгүйгээс л ийм болж байна. Халуун элгэний нь хүн байгаад, хажуу хаяанд нь сууж байсан мөртөө харахгүй үзэхгүй нь буруу!*” (Ринчен, 1967: 84) хэмээн тэмдэглэсэн байдаг.

Хоршоо үгийн ингэж хөгжин дэлгэрэх үндэс суурь нь эртний монголчуудын уран сайхны сэтгэлгээ юм. Тодруулбал, тэд юуны өмнө үг холбож шинэ нэрлэлт үүсгэж сурсан ба улмаар уг туршлагадаа дулдуйдан юмсыг адил төстэй шинжээр нь зүйрлэн шүлэглэх болсон байна. Энэ нь танин мэдэхүйн “ялгах” сэтгэлгээнд суурилах тул маш дэлгэрэнгүй, тодорхой өгүүлсэн олон мянган шад шүлгээс бүтдэг онцлогтой байв. Тухайлбал, монгол ардын аман зохиолын эртний төрөл зүйлийн нэг болох монгол туульд, туулийн гол баатрын нутаг ус, унасан хүлэг морь, ээж аав, хөрөнгө хогшил зэргийг маш тодорхой өгүүлдэг нь дурдсан “ялгах” сэтгэлгээний нөлөө юм. Үүнд зөвхөн туулийн гол баатрын тухай л гэхэд түүнийг тэнгэрлэг язгууртай болохыг дурдахын хамт бие бялдар, нүүр царай, бяраа чадал, билиг ухаан, хэл яриа, зан төрх, алхаа гишгээ, дээл хувцас, зэр зэвсгийг нэгд нэгэнгүй дүрсэлдэг болохыг тууль судлаач, доктор (Sc.D) Б.Катуу (2004) тэмдэглэжээ. Яваандаа ингэж дэлгэрэнгүй тоочин өгүүлэхийн хамт дунд нь үнэлэмж (ёс суртахууны, соёлын, эдийн) бүхий хоёр мөр (эсвэл гурван мөр) зэрэгцүүлэл шүлгээр дүгнэн хэлдэг

болсон байна. Жишээ нь, *-Өдөр эсэгчилж, шөнө өвсөн нэмбүүл гэртээ ирж хонох бүлгээ.* [üdür esükçilejü söni ebesün nembüle ger-dür-iyen irejü qonoqu büle'e. 28§] хэмээн шүлэглэн холбож байснаа

*Өдөр үзэхийн нүдэн*

*Шөнө сонсохын чихэн*

хэнээ болгохуй уу хэмээн гэр дотор тэжээвэй. [Hö'elün eke kö'üt-te-en üdür üjegü-yin nidün söni sonosqu-yin çikin ken-e bolqaquy'ü ke'en ger dotora teji'ebei. 138§] хэмээн хэлэх болсон байна. Энэ нь өмнө дурдсан дэлгэрэнгүй өгүүлэх хэлний үйл ажиллагааг хураан хэмнэж эхэлсний баримт юм. Өөрөөр хэлбэл, Өгэлүн эхийн тэжээсэн дөрвөн хөвүүдийн үүрэг, хүч зүтгэлийг нэг бүрчлэн өгүүлж болох хэдий ч тэдний тухай дэлгэрэнгүй өгүүлэх шаардлагагүйгээр үнэнч, итгэлтэй занг нь мэдэх тул өгүүлэхийн үйл ажиллагааг хэмнэн хоёр мөр зэрэгцүүлэл шүлгээр уг санаагаа илэрхийлжээ. Ингэхдээ “нүд”, “чих”-ээр төлөөлүүлсэн нь нийгмийн ороо бусгаа цагт үнэнч итгэлтэй зан, үнэн зөв мэдээлэл тун чухал болохыг илтгэсэн байна. Үүний зэрэгцээ уул зэрэгцүүлэл шүлэгт буй эсрэг утгатай үгээ тодотгон хэлж дэлгэрүүлж болно. Жишээ нь,

*Хар шөнийн зүүдэнд чинү орох би.*

*Гэгээн өдрийн сэтгэл чинү зовоох би.*

[qara sönin-ü jewüdün-tür çin-u oroqu bi. gege'en üdür-ün setkil çin-u joba'aqu bi. 201§] хэмээн товч бөгөөд тодорхой хэлэх болжээ. Монголын нууц товчоонд ингэж төлөөллийн аргаар бүтээсэн эсрэг утгатай өгүүлбэр зүйн хоршоо зэрэгцүүлэл олон гарах ба тухайлбал, 124-р зүйлд Чингис хаан Архай хасар, Тахай, Сүхэхэй, Чагурхан дөрвийг

*Холын хоочаг, ойрын одора болтугай.*

[qola-yin qo'оцаг оуира-yin odora boltuqai 124§]

хэмээн хэл мэдээ хүргэх ажлыг “тавьсан сум мэт” хурдан түргэн хийхийг зарлигдсан, 210-р зүйлд Хунаныг

*Хар шөнө гэндүү чоно, гэгээн өдөр хар хэрээ болж*

[qara söni gendü çino gege'en üdür qara kerі'e bolju 210§]

тагнан турших ажил хийхийг даалгасан байдаг. Яваандаа хүмүүсийн хийсвэрлэх чадвар нэмэгдсэнээр уг зэрэгцүүлэл шүлгээ дахин хурааж эсрэг болон ойролцоо утгатай хоршоо үг бүтээх болжээ. Жишээ нь, *Онон мөрөн өөд ирада гүйж олиц мойл тэмгэж, өдөр шөнө хоолой тэжээв.* [Onan\_müren ö'ede irada güyüjü ölırsün moyılsun temgüjü üdür söni qo'olai teji'ebe. 74§] гэх мэт. Харин уг зэрэгцүүлэл шүлэгтээ үнэлэмж шингээн дүгнэвэл хэлц үг үүснэ. Өөрөөр хэлбэл, хэлц нь хоршоо үгээс илүү хийсвэрлэж байна гэсэн үг юм. Жишээ нь, *Цагаанаа сацваас хард хахваас* [çaqa'an-a saça'asu qara-da qaqa'asu 167§], Тайчууд ах дүүгийн гашуун дуусан ядан ач хэнээ авран чадахун уу хэмээж бүхүйд намайг яахан

*Нүдний сормуус*

*Амны хахаас*

болгомуй та (та нар). [Таууісі'ut aqa de'ü-yin qaşı'un dawusun yadan haçi ken-e aburan çidaquñ'ü ke'ejü бүкүй-түр nama-yi yekin nidün-ü surmusun aman-u qaқasun bolqamui ta. 77§] гэх мэт жишээнд үгийн утгын эсрэгцлээс гадна монголчуудын уламжлалт ёс заншил, ертөнцийн тухай үзэл ойлголт шингэсэн байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, дурдсан жишээ баримт нь монгол хэлний

тэдгээр нэрийн хоршоо үг бол хийсвэрлэх сэтгэлгээний үр дүн болохын зэрэгцээ хэлний хэмнэх зарчмын нөлөөгөөр үндэстний үнэлэмж шингэсэн өгүүлбэр зүйн хоршоо зэрэгцүүллийг хураах замаар үүссэн болохыг харуулж байна.

Тэгвэл зарим хоршоо үг үүсэх болсон шалтгаан нь хэлний хэмнэх зарчим болоод монгол хэлний авианы өвөрмөц шинжид тулгуурласан байх ба тухайлбал, авианы сонслын айзам хэмнэлийг тааруулан, бие махбод хийгээд ухамсар сэтгэхүйгээс үл хамааран үүссэн бүлэг үг байна. Тухайлбал, абуй бабуи [abui babui 174§], бураа тараа [bura tara 218§], ийн тийн [eyin teyin 102§], ийм тийм [eyimün teyimün 265§] гэх мэт. Ийм төрлийн хоршоо үгийг ажиглахул монгол хэлний авианы зохицол, хэмнэл голлох нөлөөтэй нь мэдэгдэх ба доктор (Sc.D), профессор М.Базаррагчаагийн үзэхээр тэргүүн үеийн гийгүүлэгч авиа гээгдэн ойролцоо үг бүтээж, хоршоо үг бий болсон байна. Ийм хоршоо үг нь эгшгээр эхэлсэн үгийн эхний гийгүүлэгчийг сэргээх төдийгүй, тухайн үгийн гарлын бүтцийг нягтлахад чухал үүрэгтэй ажээ. Иймээс монгол хэлний эгшгээр эхэлсэн үг болгон аль нэг гийгүүлэгчээр эхэлсэн үгс байсан гэж үзэж болно (Базаррагчаа, 2017: 335-347) гэсэн сонирхолтой дүгнэлтэд хүрсэн байна.

Дурдсан жишээ баримтаас үзвэл, зөвхөн ерөнхийлөн төлөөлүүлсэн болон ерөнхийлөн бүлэглэсэн хоршоо үгийн хувьд ялгах сэтгэлгээний онцлог илрэх ба монголчуудын ертөнцийг үзэх үзэл, соёл, ёс заншлаас үүссэн хоршоо үг нь анхнаасаа утгын гүн бүтцэд нэгдсэн, өөрөөр хэлбэл үгийн сангийн нэг нэгж байсан ажээ.

#### 4. Дүгнэлт

Судалгаанаас үзвэл, Монголын нууц товчоон дахь нэрийн хоршоо үг дараах хэдэн зүйлийн аргаар үүсжээ. Тухайлбал, эртний монголчуудын аман соёлын хөгжлийн явцад хүмүүс байгаль, нийгмийн олон үзэгдлийг танин мэдэх явцдаа шинээр олж мэдсэн зүйлээ үг холбон илэрхийлж сурсан ба сэтгэлгээний хөгжлийн дараагийн түвшинд үг холбох эрдэмдээ суурилсан уран сайхны сэтгэлгээгээ хөгжүүлж улмаар шүлэглэн холбох болжээ. Ингэснээр ард түмний дунд ам дамжин яригдаж байсан зүйлс нь үгийн урлагийн гайхамшгийг илтгэсэн аман зохиолын өв болон хөгжсөн байна. Энэ хэл танин мэдэхүйн “ялгах сэтгэлгээ”-нд суурилсан учир маш дэлгэрэнгүй, тодорхой өгүүлдэг, зарим төрөл зүйл нь (тухайлбал, тууль) хэдэн мянган шад шүлгээс бүтдэг онцлогтой байв. Гэвч хүмүүсийн танин мэдэхүйн сэтгэлгээ өөрчлөгдөж, хийсвэрлэх чадвар нэмэгдэхийг дагалдан дэлгэрэнгүй, тодорхой өгүүлж байсан зүйлээ хураан дүгнэж хэлдэг болсон байна. Үүний үр дүнд ойролцоо болон эсрэг утгатай, уран цэцнээр өгүүлсэн өгүүлбэр зүйн хоршоо зэрэгцүүлэл бий болов. Энэ нь зүйр цэцэн үг, ертөнцийн гурав гэх мэт монгол ардын аман зохиолын шинэ төрөл зүйл, үгийн сангийн хувьд шинэ нийлмэл нэгж үүсэх нөхцөл бүрдсэн байна. Тухайлбал, сэтгэлгээний хөгжлийн дараагийн түвшинд уул хоёр мөр зэрэгцүүлэл шүлгээ хураан товчилбол хоршоо үг, үнэлэмж шингээн хийсвэрлэн дүгнэвэл хэлц үг үүсжээ. Тэгвэл зарим нэрийн хоршоо үг нь хэлний хэмнэх зарчмын нөлөөгөөр ерөнхийлөн бүлэглэх, ерөнхийлөн төлөөлүүлэх аргаар үүссэн ба ийм үг танин мэдэхүйн ялгах сэтгэлгээний

нөлөөгөөр хэл зүйн нөхцөлөөр харилцан адилгүй хувилдаг байв. Удаах бүлэг үгс нь монголчуудын ертөнцийг үзэх үзэл, соёл, шашин шүтлэгээс үүдэлтэй анхнаасаа утгын гүн бүтцэд нэгдсэн өргөн утга агуулга бүхий үг байна. Харин дөрөв дэх бүлэг үгс нь монгол хэлний авианы өвөрмөц шинжид тулгуурласан бөгөөд тухайлбал, авианы сонслын айзам хэмнэлийг тааруулан, бие махбод хийгээд ухамсар сэтгэхүйгээс үл хамааран үүсжээ.

### Ном зүй

- Бадамдорж Д.** (2023). Монгол хэлний хоршоо үгийн утга зүйн судалгааны асуудалд-*Монгол хэлний утга зүйн судалгаа*, Улаанбаатар. [Badamdorj D. Mongol khelnii khorshoo ügiin utga züin sudalgaany asuudald [On Semantic issues in Compound words in the Mongolian language – *Collection of Research articles on Mongolian semantics*]. Ulaanbaatar, 2023]
- Базаррагчаа М.** (2017). Үе-утгалбар задгайрах хуулийг хоршоо үгийн хувилбараар магадлах нь - *Монгол хэлний авиалбар судлал*, Улаанбаатар. [Bazarragchaa M. Üye-utgalbar zadgairakh khuuliig khorshoo ügiin khubilbaraar magadlakh ni [Testing the law of Syllable-Morpheme separation using variants of compound words – *Proceedings of Mongolian phonology research*]. Ulaanbaatar, 2017]
- Баттулга Ч.** (2012). Монгол хэлний хоршоо үгийн үүсэл гарлын асуудалд - *Монгол судлалын чуулган*, №12 (47), Жиком пресс ХХК, Улаанбаатар. [Battulga Ch. Mongol khelnii khorshoo ügiin үүсел garlyn asuudald [On the origin and formation of compound words in the Mongolian language – *Mongolian Studies Conference*]. No.12 (47), Jikom LLC, Ulaanbaatar, 2012]
- Дулам С.** (2018). Галаар бэлгэдэх бэлгэдэл домог зүйтэй холбогдох нь – *Домог зүй, бөө мөргөлийн судалгаа*, Улаанбаатар. [Dulam S. Galaar belgedeh belgedel domog зүйтэй kholbogdokh ni [The Symbolism of fire and its connection to mythology – *Collection of Research articles on mythology and shamanism*]. Ulaanbaatar, 2018]
- Катуу Б.** (2004). *Монгол туулийн дүрийн тогтолцоо*. Мөнхийн үсэг ХХК, Улаанбаатар. [Katu. B. *Mongol tuuliin дүрийн togtoltsoo* [The Character system of Mongolian epics]. Münkhiin үсэг LLC, Ulaanbaatar, 2004]
- Мөнхсайхан С.** (2024). Монголын нууц товчоо эрдэм шинжилгээний хөрвүүлэг. Соёмбо принтинг ХХК, Улаанбаатар. [Munkhsaikhan S. *Mongolyn nuuts товчоо Erdem shinjilgeenii khörvүүлэг* [The Secret History of the Mongols]. Soyombo LLC, Ulaanbaatar, 2024]
- Нансалмаа Н., Долгор С.** (2014). *Танихуйн хэл шинжлэл*. Соёмбо принтинг ХХК, Улаанбаатар. [Nansalmaa N., Dolgor S. *Tanikhuin khel шинжлэл* [Cognitive linguistics]. Soyombo LLC, Ulaanbaatar, 2014]
- Ринчен Б.** (1967). *Монгол бичгийн хэлний зүй дөтгөөр дэвтэр* - Өгүүлбэр зүй, Шинжлэх ухааны академийн хэвлэл, Улаанбаатар. [Rinchen B. *Mongol bichgiin khelzii*. [A Primer of the grammar of Mongolian script: Syntax]. Academy of Sciences Press, Ulaanbaatar, 1967]

- Цэрэнсодном Д.** (2011). *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*. Тод бичиг ХХК, Улаанбаатар. [Tserensodnom D. *Mongol aman zokhiolyn tailbart deej bichig* [Samples of annotated Mongolian folklore, Tod bichig LLC, Ulaanbaatar, 2011]
- Kuribayashi. H., Choijinjab.** (2001) Word-and Suffix-Index to “The Secret History of the Mongols” (元朝秘史,語全単語-語尾索引) based on the Romanized Transcription of L.Ligeti, Center for Northeast Asian Studies №4, Sendai 2001.



**Open access:** This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>